



ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

20 24 оны 02 сарын 23 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

“Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр” батлах тухай

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.3, 6.3.7 дахь заалт, 28 дугаар зүйлийн 28.8.2, 28.8.4 дэх заалт, Монгол Улсын Засгийн газар, Олон Улсын Хөгжлийн Ассоциаци хооронд 2020 оны 09 дүгээр сарын 07-ны өдөр байгуулсан Санхүүжилтийн хэлэлцээр, Сангийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар хооронд байгуулсан 2023 оны “Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төсөл”-ийн зээллэгийн хөрөнгийг дамжуулан зээлдэх 132/01/207ХХҮЕГ/73 дугаар гэрээг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Бичил бизнес эрхлэгчдийн аж ахуй эрхлэх санхүүгийн болон санхүүгийн бус чадавхыг дээшлүүлэх замаар ажлын байр хадгалах, шинээр бий болгох, тогтвортой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн “Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр”-ийг хавсралт ёсоор баталсугай.

2. “Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр”-ийн удирдамж, төсвийн хуваарийг боловсруулан батлуулж, хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдлага, арга зүйгээр ханган хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, төслийн захирал (Л.Батсайхан)-д даалгасугай.

3. “Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг батлагдсан удирдамжийн дагуу зохион байгуулж, тогтмол тайлагнаж ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар /З.Энхболд/, “Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төсөл” /Ц.Байгалмаа/-д тус тус үүрэг болгосугай.

ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА,
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
САЙД



Х.БУЛГАНТУЯА



Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн
2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн
04 дүгээр тогтоолын хавсралт



БИЧИЛ БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР

Нэг. Зорилго

Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр нь бичил бизнес эрхлэгчдийн аж ахуй эрхлэх санхүүгийн болон санхүүгийн бус чадавхыг дээшлүүлэх замаар ажлын байр хадгалах, шинээр бий болгох, улмаар зорилтот хүн амын тогтвортой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилготой юм.

Хоёр. Хамрах хүрээ

Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих хөтөлбөрт дараах иргэн хамрагдана.

- 2.1. Хувиараа хөдөлмөр эрхлэгч¹;
- 2.2. Малчин²;
- 2.3. Нөхөрлөл, хоршоо байгуулах иргэн³;
- 2.4. Бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч⁴;
- 2.5. Гадаад улсад хөдөлмөр эрхэлж байгаад буцаж ирсэн иргэн⁵.

Гурав. Баримтлах зарчим

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ дор дурдсан зарчмыг баримтална. Үүнд:

- 3.1. Арга хэмжээг хэрэгжүүлж, хянаж, үнэлэхдээ үр дүнд суурилсан зарчмыг баримтлах;
- 3.2. Арга хэмжээг хэрэгжүүлэхэд оролцогч талуудын хамтын ажиллагааны хүрээ, талуудын эрх, үүрэг тодорхой байх;
- 3.3. Иргэдийг үл ялгаварлах;
- 3.4. Хэрэгжүүлэх арга хэмжээний нийгэм, байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг тодорхойлох, хязгаарлах, бууруулах;
- 3.5. Авилгаас урьдчилан сэргийлэх, авлигаас ангид ажиллах⁶;
- 3.6. Ил тод, нээлттэй байдлыг хангах;
- 3.7. Жижиг зээл авсан иргэдийн 50-аас доошгүй хувь нь эмэгтэйчүүд байх.

Дөрөв. Хэрэгжүүлэх арга хэмжээ⁷

4.1. Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр нь дараах арга хэмжээнээс бүрдэнэ. Үүнд:

¹ "Хувиараа хөдөлмөр эрхлэгч" гэж дангаараа болон бусадтай хамтран аж ахуй эрхэлж, татварын албанд бүртгүүлэн бизнесийнхээ үйл ажиллагаанд нөлөөлөх шийдвэрээ хараат бусаар бие даан гаргадаг иргэнийг;

² "малчин" гэж мал аж ахуй эрхэлж үндсэн орлогоо олдог иргэнийг;

³ "Нөхөрлөл, хоршоо байгуулах иргэн" гэж Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасан журмын дагуу нөхөрлөл, хоршоогоо улсын бүртгэлд бүртгүүлэхээр хүсэлт гаргасан иргэдийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийг;

⁴ "Бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч" гэж 50 хүртэл сая төгрөгийн үйлдвэрлэлийн хөрөнгө, эсхүл үйлчилгээний борлуулалтын орлого бүхий үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, иргэнийг.

⁵ "Гадаад улсад хөдөлмөр эрхэлж байгаад буцаж ирсэн иргэн" гэж 6 сараас дээш хугацаагаар гадаад улсад ажиллаж, амьдарч байгаад сүүлийн 48 сарын дотор эх орондоо буцаж ирсэн иргэнийг хэлнэ.

⁶ Олон улсын Сэргээн босголт, хөгжлийн банк, Олон Улсын Хөгжлийн Ассоциацийн зээл, буцалтгүй тусламжийн санхүүжилттэй төслүүдэд баримтлах "Залилан, авлигаас урьдчилан сэргийлж, таслан зогсоох удирдамж" нь энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оролцогч бүх талуудад хамаатай болно.

⁷ Арга хэмжээний хэрэгжилт, зохион байгуулалтыг дэлгэрэнгүй тодорхойлсон удирдамжийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар батална.

4.1.1. Жижиг зээлд хүсэлт гаргах боломжтой иргэдэд зориулсан зээлийн өмнөх сургалт;

4.1.2. Жижиг зээлийн арга хэмжээ;

4.1.3. Зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээ.

4.2. Арга хэмжээний (4.1.1-4.1.3) хэрэгжилт, зохион байгуулалтыг дэлгэрэнгүй тодорхойлсон удирдамжийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар батална.

4.3. Жижиг зээлийг Олон Улсын Хөгжлийн Ассоциацийн санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төсөл”-өөс Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаар дамжуулан олгоно.

4.4. Зээлийн өмнөх сургалт, зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээ болон бусад холбогдох үйл ажиллагааны зардлыг төслөөс, төслийн хөрөнгийн дансаар дамжуулан санхүүжүүлнэ.

4.5. Зээлийн өмнөх сургалт

4.5.1. Зээлийн өмнөх сургалт нь зээл хүсэгчдийн бизнесийн санааг хөгжүүлэх, аж ахуй эрхлэх төсөл, төлөвлөгөө боловсруулах ур чадварыг дээшлүүлэх, бичил бизнес эрхлэгчдийн бизнесийн үйл ажиллагаатай холбоотой байгаль орчин, нийгмийн эрсдэлийг бууруулах, шийдвэрлэх хариуцлагын талаарх ойлголтыг нэмэгдүүлэх, жижиг зээл авахад тавигдах шалгуур, бүрдүүлэх шаардлагатай баримт бичиг, зээлийн төслийг сонгон шалгаруулах аргачлал зэргийг тайлбарлан таниулахад чиглэсэн 2 өдрийн сургалт байна.

4.5.2. Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага зээлийн өмнөх сургалтыг үлгэрчилсэн хөтөлбөр, батлагдсан зардлын жишгийг⁸ баримтлан зохион байгуулна.

4.6. Бичил бизнес эрхлэгчдэд олгох жижиг зээл

4.6.1. Жижиг зээлийг олгохдоо Засгийн газрын 2021 оны 340 дүгээр тогтоолоор батлагдсан журамд⁹ заасан хэмжээг баримтална. Хамрах хүрээнд ногдох хөрөнгийн хувь хэмжээг энэ хөтөлбөрийн 4.2-т заасан удирдамжид тусгана.

4.6.2. Жижиг зээл олгох арилжааны банкныг Засгийн газрын 2021 оны 340 дүгээр тогтоолоор баталсан журам болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын баталсан холбогдох тушаалыг¹⁰ баримтлан сонгон шалгаруулна.

4.6.3. Шалгарсан банктай гэрээ байгуулахад холбогдох журамд заасан үндсэн нөхцөлүүд болон төслийн санхүүжилтийн хэлэлцээр дэх шаардлагуудыг тусган хэрэгжүүлж ажиллана.

4.6.4. Жижиг зээлийн арга хэмжээнд нийт 550-аас доошгүй¹¹ иргэнийг хамруулсан байна.

4.6.5. Жижиг зээлийг 36 сар хүртэл хугацаатай олгоно. Зээлдэгчийн хүсэлтээр зээлийн үндсэн төлбөрөөс эхний 6 сар хүртэлх хугацаанд чөлөөлж болно. Зээлдэгчид зээлийн үндсэн төлбөрөөс чөлөөлөх хугацааг олгох боломж болон түүнээс гарч болох үр дагаврын талаар тайлбарлана.

4.6.6. Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага жижиг зээлийн төслийг урьдчилан шалгаруулах ажлын хэсгийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн байгуулна. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд зээл олгохоор шалгарсан арилжааны банкны тухайн орон нутаг дахь салбарын төлөөллийг оролцуулна. Жижиг зээлийн төслийг хүлээн авах, урьдчилан шалгаруулах, банканд тодорхойлолт гаргах, сонгосон төслийн жагсаалтыг холбогдох баримт бичгийн хамт банканд хүргүүлэх ажлыг ил тод, нээлттэй зохион байгуулна.

⁸ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/16 дугаар тушаалд заасан Зээлийн өмнөх сургалтын хөтөлбөр, зардлын жишиг.

⁹ “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүү нь нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам”-ын 2.24.

¹⁰ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/93 дугаар тушаал болон энэ хөтөлбөрийн 4.2-т заасан удирдамж.

¹¹ Монгол Улс, Олон Улсын Хөгжлийн Ассоциаци хоорондын Санхүүжилтийн хэлэлцээр дэх үр дүнгийн үзүүлэлт.

4.6.7. Жижиг зээлийн төслийн байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг төсөл хэрэгжүүлэгчдэд ойлгуулах, хязгаарлах, бууруулах чиглэлээр боловсруулсан хяналтын болон үнэлгээний арга хэрэгсэл, зааварчилгааг жижиг зээлийн төслийг шалгаруулах, хянах, хэрэгжүүлэх явцад мөрдөж ажиллана.¹²

4.7. Зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээ

4.7.1. Зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээг энэхүү арга хэмжээний хүрээнд жижиг зээл авсан иргэн бүрд үзүүлнэ. Үүнд:

1) Бизнес хөгжлийн сургалт (аж ахуй хөгжүүлэлт, санхүүгийн бүртгэл, маркетинг, борлуулалтын чиглэлээр) 20 цагийн хөтөлбөртэй байх бөгөөд сургалтыг танхим болон цахим (зайн) хосолсон хэлбэрээр зохион байгуулна.

2) Бизнесийн арга зүйн зөвлөгөө ба менторинг үйлчилгээ (бүтээгдэхүүн хөгжүүлэлт, сайжруулалт ба менежментийн чиглэлээр) зээл авсан иргэний онцлог, хэрэгцээнд нийцүүлсэн 10 цагийн хөтөлбөртэй байна.

4.7.2. Жижиг зээлийн төслийг урьдчилан шалгаруулах ажлын хэсэг (4.3.4-д заасан) зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээг хэрэгжүүлэх мэргэшсэн байгууллагыг ил тод, нээлттэй сонгон шалгаруулна. Ажлын хэсэг цаашид гэрээ байгуулан, гэрээний биелэлтэд хяналт тавьж, дүгнэж ажиллана.

4.7.3. Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага шалгаруулалтын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг ажлын хэсгийн шийдвэр гарснаас хойш ажлын 5 хоногт багтаан байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбар болон бусад мэдээллийн хэрэгслээр олон нийтэд ил тод мэдээлнэ.

4.7.4. Зээлийн өмнөх болон зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээг хэрэгжүүлэхэд шаардагдах жишиг зардал болон холбогдох гэрээний загварыг 4.2-т заасан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын батлах хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдамжид тусгана.

4.7.5. Жижиг зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээ үзүүлэх байгууллага зээл авсан иргэний хэрэгжүүлж буй төслийн байгаль орчин, нийгэмд учруулж болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, хязгаарлах, бууруулах болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөгөө өгч ажиллана.

4.7.6. Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага нь жижиг зээл авсан иргэд бие биеэсээ суралцах, туршлагаа хуваалцах, түншлэлийн харилцаа холбоо тогтоох, нэмүү өртгийн сүлжээнд холбох, үйлдвэрлэлийн дэвшилтэт технологи, санаачилгын талаар мэдээлэл авах болон зээл авсан иргэдийн үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүнийг сурталчлах, борлуулахад чиглэсэн үзэсгэлэн, яармаг зэрэг үйл ажиллагааг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бусад хөтөлбөрүүдтэй уялдуулан зохион байгуулна.

Тав. Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих арга хэмжээний хяналт, үнэлгээ

5.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц болон хяналт шинжилгээ, үнэлгээ нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжүүлэн хэрэгжүүлж буй бусад хөтөлбөрийн адил Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны хяналт-шинжилгээ, үнэлгээний журамд нийцсэн байна.

5.2. Хөтөлбөрийн арга хэмжээний үр дүнг хянаж, үнэлэхдээ захиргааны аргаар цуглуулсан тогтмол тоон мэдээ, хөтөлбөрийн хэрэгжилтийг газар дээрээс нь цуглуулсан чанарын мэдээ, хөндлөнгийн мөшгөх болон үр шим хүртэгчдийн сэтгэл ханамжийг тодорхойлох судалгаа зэрэг арга хэрэгслийг зохистой ашиглана.

5.3. Арга хэмжээ тус бүрийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын баталсан бүртгэл, хяналт, тайлангийн маягтын дагуу тайлагнана.

¹² Хяналт, үнэлгээний арга хэрэгсэл, зааварчилгааг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар батална.

Бүртгэл мэдээлэл, үйл ажиллагааны хяналтын болон тайлангийн тоо мэдээг оролцогч талуудаас цахимаар болон бичгээр хүлээж авна.

5.4. Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих хөтөлбөрт хамрагдсан иргэдээс зээл авснаас нь 6 сарын дараа үр шим хүртэгчдийн сэтгэл ханамжийг үнэлэх зорилгоор мөшгөх судалгаа авна.

5.5. Мөшгөх судалгааг холбогдох аргачлалын дагуу судалгааны мэргэшсэн байгууллагаар гүйцэтгүүлнэ.

5.6. Арга хэмжээний хэрэгжилт, үр дүнг үнэлэхэд дараах шалгуур үзүүлэлтийг үндэслэнэ. Үүнд:

5.6.1. Жижиг зээл авсан иргэдийн тоо, хүйсээр;

5.6.2. Нийт олгогдсон жижиг зээлийн санхүүжилтийн хэмжээ;

5.6.3. Жижиг зээл авснаас хойш багадаа 6 сарын хугацаанд аж ахуй, үйл ажиллагаагаа тогтвортой эрхэлсэн иргэдийн нийт зээлд хамрагдсан иргэдийн тоонд эзлэх хувь, хүйсээр;

5.6.4. Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих арга хэмжээнд хамрагдсан иргэдийн сэтгэл ханамжийн үнэлгээ.

Зургаа. Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн менежмент

6.1. Хөтөлбөрт хамрагдсан бичил бизнес эрхлэгч нь байгаль орчин, нийгмийн эрсдэлийн удирдлагын шаардлага, хариуцлагыг хүлээнэ. Тодорхой зохицуулалтуудыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас батлах хөтөлбөр хэрэгжүүлэх удирдамжид тусгана.

---ooOoo---